



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 50


Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Дундговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Гончигсүрэн овогтой Эрдэнэбаатарыг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор, 4-р багийн ахмад малчин Шаравсамбуу овогтой Нямцэрэн, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Нямсүрэн овогтой Дэлгэрцэцэг нарыг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Шагналын материалыг холбогдох хууль, журам, зааврын дагуу бүрдүүлж, дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Засаг дарга (С.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.БАТЖАРГАЛ